

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар  
сарын 21-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Хөдөө аж ахуйг дэмжих санг “Хөдөө аж ахуйн корпорац” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгосноор хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого нэмэгдэж, зах зээлийн бодит эрэлт, хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, шударга, хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийн сүлжээ бий болгох, дотоодын үйлдвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж, хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төрийн өмчит компани болсноор хаврын бэлтгэл ажилд хүндрэл үүсэх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин компанийн хэлбэрт шилжсэнээр гарах бодитой өөрчлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн компанийн засаглал, өмчлөл, чиг үүргийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа хэдий ч тусгай сангийн чиг үүргийг шинээр байгуулагдах аж ахуйн нэгжид бүрэн, хийдэлгүй шилжүүлэх зорилго бүхий “хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоол”-ын төслийг шинээр боловсруулах, улмаар шинээр байгуулагдах компанийн засаглалд малчид, иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллийг оруулах замаар хамтын оролцоог хангах, төрийн өмчийг хязгаарлах нь зүйтэй гэсэн санал гаргасан болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН